

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД, БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2025 оны 01 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар А/05-А/07

Улаанбаатар хот

“Журам батлах тухай”

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.13 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.2.14, 14.2.16 дахь заалт, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.3.7 дахь дэд зорилтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Цэргийн алба хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхийг Боловсролын яамны Мэргэжлийн болон техникийн боловсролын газар, Боловсролын үнэлгээний төв, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга (бригадын генерал Д.Ганхуяг), Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга (Х.Батжаргал) нарт даалгасугай.



Батлан хамгаалахын сайд, Боловсролын сайдын
хамтарсан 2025 оны 02 дугаар сарын 02-ны
өдрийн 1/05, 1/07 дугаар тушаалын хавсралт

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫГ МЭРГЭШҮҮЛЭХ, МЭРГЭЖИЛ ЭЗЭМШҮҮЛЭХ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

ATA12937 9116621 9024070582

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлын хүрээнд цэргийн алба хаагчийг мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Цэргийн алба хаагчийг мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулахдаа Зэвсэгт хүчний тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.3.7 дэх хэсэгт тусгагдсан "ЭХ ОРНЫ ДУУДЛАГА-ЭР ЦЭРГИЙН АЛБА" дэд зорилт болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

1.3. Журмын үйлчлэлд Зэвсэгт хүчний офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдыг (цаашид "Цэргийн алба хаагч" гэх) Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад (цаашид "Сургалтын байгууллага" гэх) суралцуулан мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагааг хамааруулна.

Хоёр. Цэргийн алба хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх сургалтад бүртгэх

2.1. Зэвсэгт хүчний нэгтгэл, анги нь сургалтад хамрагдах цэргийн алба хаагчдыг сонгох, бүртгэх, нийслэл болон орон нутаг дахь сургалтын байгууллагатай суралцуулах гэрээг байгуулах, суралцуулах арга хэмжээг Зэвсэгт хүчний Жанжин штабын өмнө хариуцаж, зохион байгуулна.

2.2. Зэвсэгт хүчний Жанжин штаб нь улс орны бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай мэргэжлээр цэргийн алба хаагчдыг бэлтгэх санал, мэргэжлийн чиглэл, элсэлтийн хяналтын тоо, захиалгыг жил бүрийн 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.3. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Зэвсэгт хүчний Жанжин штабаас ирүүлсэн санал, захиалгыг Сургалтын байгууллагын элсэлтийн хяналтын тоо, мэргэжлийн чиглэлд тусган батална.

2.4. Сургалтад хамрагдах цэргийн алба хаагч дараах баримт бичгийг бүрдүүлж, бүртгүүлнэ. Үүнд:

- Өргөдөл;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Цээж зураг 2 хувь;
- Боловсролын баримт бичгийн хуулбар.

2.5.Зэвсэгт хүчний Жанжин штаб нь элсэгчдийн мэдээллийг "Маягт-1"-ийн дагуу Сургалтын байгууллагад жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.

Гурав. Сургалт зохион байгуулах

3.1.Мэргэжлийн боловсролын сургалтыг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 7.1 дэх хэсэгт заасан стандарт, нийтлэг шаардлагын дагуу 1 жилийн хугацаанд зохион байгуулна.

3.2.Мэргэжлийн сургалтыг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.4 дэх заалтын дагуу зохион байгуулж болно.

3.3. Энэхүү журмын 3.1 болон 3.2 дахь хэсэгт заасан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг Зэвсэгт хүчний Жанжин штабаас ирүүлсэн саналд үндэслэн Боловсролын ерөнхий хуулийн 26.1.7 дахь заалтын дагуу батлагдсан мэргэжлийн болон техникийн боловсролын мэргэжлийн чиглэл, индексийн дагуу сургалтын байгууллага боловсруулна.

3.4. Журмын 3.1 дэх заалтад заасан сургалтын хөтөлбөрийг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.12 дахь хэсэгт заасан загвар, шаардлагын дагуу боловсруулж, мөрдөнө.

3.5. Журмын 3.2 дахь заалтад заасан сургалтын хөтөлбөрийг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.15 дахь хэсэгт заасан журмын дагуу боловсруулж, мөрдөнө.

3.6. Мэргэжлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийн ерөнхий суурь хэсгийн чадамжийн нэгжийг цэргийн мэргэжил олгох хөтөлбөрийн мэргэжлийн суурь хичээлийн агуулга, цагтай дүйцүүлж болно.

3.7. Үйлдвэрлэлийн дадлагыг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын болон цэргийн анги, байгууллагын материаллаг баазыг түшиглэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн зохион байгуулна.

3.8. Төгсөлтийн үнэлгээг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8.1 дэх хэсэгт заасан "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагч, төгсөгчийн мэдлэг, ур чадвар, чадамжийг үнэлж, баталгаажуулах журам"-ын дагуу зохион байгуулна.

Дөрөв. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон Сургалтын байгууллагын хүлээх үүрэг

4.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хүлээх үүрэг:

4.1.1. Зэвсэгт хүчний Жанжин штабаас ирүүлсэн санал, захиалгыг үндэслэн Сургалтын байгууллагын элсэлтийн хяналтын тоо, мэргэжлийн чиглэлийг батлах;

4.1.2. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь заалтын дагуу төгсөгчдөд "Чадамжийн гэрчилгээ", "Мэргэжлийн үнэмлэх" олгох.

4.2. Сургалтын байгууллагын хүлээх үүрэг:

4.2.1.Сургалтын үйл ажиллагааг батлагдсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу Зэвсэгт хүчний Жанжин штаб, нэгтгэл, анги, байгууллагатай хамтран зохион байгуулах;

4.2.2.Үйлдвэрлэлийн дадлагыг Сургалтын байгууллагын болон анги, нэгтгэлийн материаллаг баазыг түшиглэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;

4.2.3. Сургалтын байгууллага нь төгсөгчдийн тоо болон төгсөлтийн баримт бичгийн захиалгыг төгсөх хугацаанаас 21 хоногийн өмнө "Маягт-2"-ын дагуу гарган Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

4.2.4. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчийн талаар санал, дүгнэлт гаргах;

4.2.5. Төгсөгчийг ажлын байраар хангах үйл ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

4.3. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хүлээх үүрэг:

4.3.1. Зэвсэгт хүчний Жанжин штабын сургалтын асуудал хариуцсан нэгжийг бодлогын удирдамжаар хангах;

4.3.2. Зэвсэгт хүчний Жанжин штабаас гаргасан мэргэжил, элсэлтийн хяналтын тоонд хяналт тавих, бодлогын удирдамжаар хангах.

4.4. Зэвсэгт хүчний Жанжин штабын хүлээх үүрэг:

4.4.1.Элсэгчдийн мэдээллийг "Маягт-1"-ийн дагуу Сургалтын байгууллагад жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэх;

4.4.2.Үйлдвэрлэлийн дадлагын үйл ажиллагааг Зэвсэгт хүчний нэгтгэл, анги байгууллагын болон Сургалтын байгууллагын дадлагын орчныг түшиглэн төлөвлөгөөний дагуу хамтран зохион байгуулах;

4.4.3.Цэргийн алба хаагчдыг суралцах хугацаанд нь Сургалтын байгууллага, Зэвсэгт хүчний анги, байгууллага хооронд тээвэрлэх асуудлыг хариуцах;

4.4.4.Суралцах хугацаанд цэргийн алба хаагчдыг хооллох болон хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн асуудлыг хариуцах;

4.4.5.Төгсөгчийн "Чадамжийн гэрчилгээ", "Мэргэжлийн үнэмлэх"-ийн зардлыг хариуцах.

Тав. Сургалтын санхүүжилт

5.1.Сургалтын санхүүжилтийг Боловсролын ерөнхий хуулийн 38.2 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэнэ.

5.2.Бусад эх үүсвэр.

Зургаа. Хэрэгжилтийг тайлагнах, хяналт тавих

6.1. Элсэлт, сургалт, төгсөлтийн мэдээ, тайлан, судалгааг сургалтын үйл ажиллагаа явуулж буй Сургалтын байгууллага нь Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад зохих журмын дагуу хугацаанд нь хүргүүлнэ.

6.2. Журмын хэрэгжилтийн явц, үр дүнд Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон Зэвсэгт хүчний Жанжин штаб хяналт тавьж ажиллана.

Долоо. Бусад

7.1. Энэхүү журмыг 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн 4 жилийн хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

7.2. Журмын хэрэгжилттэй холбоотой нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

—oOo—

Мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх
сургалтад хамрагдах цэргийн алба хаагчдын мэдээлэл
..... МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

20 оны дугаар сарын -ны өдөр

Д/д	Овог	Нэр	Регистрийн дугаар	Мэргэжлийн нэр	Үндсэн харьяалал	Харьяалагдах цэргийн нэгтгэл, анги, байгууллага
1						
2						
3						
...						

Судалгаа гаргасан:

.....
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

.....
(овог, нэр)

Хянасан:

.....
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

.....
(овог, нэр)

Цэргийн алба хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх
сургалтыг зохион байгуулах ажлын хүрээнд
МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ /доогуур
зурах/-ийн сургалтад хамрагдсан цэргийн алба хаагчдын
төгсөлтийн талаарх мэдээлэл

20.... оны дугаар сарын-ны өдөр

Д/д	Овог	Нэр	Регистрийн дугаар	Мэргэжлийн нэр	Үндсэн харьяалал	Олгох бичиг баримт
1						
2						
3						
...						

Судалгаа гаргасан:

Сургалтын албаны дарга

.....
(гарын үсэг)

.....
(овог, нэр)

Хянасан:

Захирал

.....
(гарын үсэг)

.....
(овог, нэр)